

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

Агуулга.....	1
1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал.....	11
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	13
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АХБ	Азийн Хөгжлийн Банк
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
БСШУСЯ	Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам
ТУХ	Төслийн Удирдах Хороо
ТХН	Төслийн Хэрэгжүүлэх Нэгж



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙН ҮЕД
БОЛОВСРОЛЫН ЧАНАР,
ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ
ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ З.
МӨНХТУЯА ТАНАА

2020.04.30 № 06/1448
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага


Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудитын тайлан

2.1. Оршил

“Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төслийн зохицуулагч З.Мөнхтуяа Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчид Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн заавар, аргачлалд нийцсэн санхүүгийн програм хангамж ашиглах, Шилэн дансны тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын хуулийг дагаж мөрдөх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 25-наас 2020 оны 04 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Далайван Аудит ХХК-ийн захирал Ц.Жигдэн хянан удирдаж, чанарын хяналтын менежер М.Болормаа, аудитор Ж.Жаргалсүрэн нар хэрэгжүүлэв.

“Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 02 дүгээр сарын 05-ны өдрийн 03/2020 дугаар бүхий албан бичгээр хуулийн хугацаанд хүргүүлсэн байна. Далайван Аудит ХХК нь 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 35/2020 тоот албан бичгээр төслийн нэгжийн санхүүгийн тайланг хүлээн авч аудитын ажлыг эхлүүлсэн.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБООУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

МУЗГ, АХБ-ны хооронд 2018 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр байгуулсан зээлийн хэлэлцээрээр нийт 50.7 сая ам.долларын өртөг бүхий “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийг хэрэгжүүлэхэд АХБ-ны ердийн хөрөнгийн эх үүсвэрээс 50.0 сая ам.долларын хөнгөлттэй зээл олгохоор болсон. Зээлийн хэлэлцээр нь 2018 оны 04 дугаар сарын 30-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон. Төсөл хаах хугацаа 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдөр. МУЗГ-аас 0.7 сая ам.долларыг мөнгөн бус буюу татварын чөлөөлөлт хэлбэрээр санхүүжүүлнэ.

Төсөл нь эдийн засгийн хүндрэлийн үед сургуулийн өмнөх, бага, дунд боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах зорилготой. Төсөл дараах 5 үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдтэйгээр үйл ажиллагаа явуулдаг.

1. Улаанбаатар хот болон зарим аймгийн төвийн сургууль, цэцэрлэгийн хүчин чадлыг нэмэгдүүлэх
2. Ерөнхий боловсролын хөтөлбөрийн ба үнэлгээний шинэчлэлийг эцэслэх
3. Сургалтын хөтөлбөрийн хэрэглэгдэхүүнийг бүрдүүлж хангах
4. Сайжруулсан хөтөлбөр ба үнэлгээний чиглэлээр багш, удирдах ажилтнуудын мэдлэг, чадварыг дээшлүүлэх
5. Боловсролын үйлчилгээний төлөвлөлт, удирдлагын тогтолцоог бэхжүүлэх

Тайлант оны эцсийн байдлаар нийт 9.1 сая ам.долларын гэрээ байгуулж, 4.8 сая ам.долларын зарцуулалт хийсэн. МУЗГ-ын санхүүжилтаас зардал гараагүй.

“Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНБООУС, түүнд нийцүүлэн баталсан төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн журам, зааврын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”
- Сангийн сайдын 2007 оны 326 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлангийн бүрэлдэхүүн болох Засгийн газрын шугамаар авч, ашиглаж буй хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, засгийн газрын тусгай санд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”

- Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”.

Тайлант хугацаанд төслийн нэгжийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан заавар, аргачлалд томоохон шинэчлэлт, өөрчлөлт ороогүй байна.

Харин татвар, нийгмийн даатгалын холбогдох хуульд орсон дараах өөрчлөлтүүд нөлөөлсөн. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон;

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус төсөл нь өөрийн үйл ажиллагаанд тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулаагүй.

“Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл” нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Инфосистемс” ХХК-ийн “Пакс” программ хангамж ашигладаг.

“Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

Төсөл нь төлөвлөсөн үйл ажиллагааг тогтоосон хугацаанд, үр дүнтэй хэрэгжүүлэх, зээлийн хөрөнгийг зорилгын хүрээнд үр ашигтай зарцуулах, хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, ил тод байдлыг хангахын тулд төслийн гүйцэтгэлийн хяналт, санхүүгийн хяналт, худалдан авах үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлдэг. АХБ болон төслийн гүйцэтгэгч байгууллагаас төслийн үйл ажиллагааны үе шат бүрт хяналт тавьж ажилладаг.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын гүйцэтгэлийн үе шатанд 3 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төслийн зардлын гүйцэтгэлд үндэслэн гадаад зээлийн эх үүсвэрээс санхүүжилт хүлээн авдаг. Иймээс нийт зардлын дүнг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 10,753,791.7 мянган төгрөгөөс 215,075.8 мянган төгрөгөөр тооцон материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа. Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг өөрчлөөгүй болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн үйл ажиллагаа 2019 оны 01 дүгээр сард эхэлсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	138,835.4	138,835.4
Авлага	-	13,882.6	13,882.6
Бараа материал	-	8,235.3	8,235.3
Үндсэн хөрөнгө	-	279,444.3	279,444.3
Хуримтлагдсан элэгдэл	-	(28,635.3)	(28,635.3)
Биет бус хөрөнгө	-	8,250.0	8,250.0
Хуримтлагдсан элэгдэл	-	(1,490.6)	(1,490.6)
Дуусаагүй барилга	-	1,650,827.5	1,650,827.5
Нийт хөрөнгө	-	2,069,349.1	2,069,349.1
Богино хугацаат өр төлбөр	-	188,436.3	188,436.3
Урт хугацаат өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оруулсан капитал / засгийн газрын сан, орон нутгийн сан/	-	-	-
Хуримтлагдсан үр дүн	-	188,436.3	188,436.3
Өмнөх оны үр дүн	-	-	-
Тайлант оны үр дүн	-	1,880,912.8	1,880,912.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	-	2,069,349.1	2,069,349.1

Мөнгөн хөрөнгө: Төсөл нь тайлант оны эцэст ам.долларын дансны үлдэгдэл 111,439.0 мянган төгрөг, төгрөгийн дансдын нийт үлдэгдэл 27,396.4 мянган төгрөг тайлагнасан.

Авлага: БСШУСЯ-нд шилжүүлсэн барилгын ажлын гэрээнүүдийн урьдчилгаа төлбөрийн барьцаа 11,630.3 мянган төгрөг, төслийн хэрэгцээний бичгийн цаас, цэвэрлэгээний материал, өдөр тутмын сонингийн зарын дараа тооцооны авлага болон олон улсын ярианы барьцаа зэрэгт нийт 2,160.6 мянган төгрөг, татварын илүү төлөлт 91.7 мянган төгрөгийн үлдэгдэл тайлагнасан.

Бараа материал: Тайлант оны эцсийн байдлаар 7,845.1 мянган төгрөгийн бичиг хэрэг, аж ахуйн материал, сэлбэг хэрэгсэл, 390.2 мянган төгрөгийн шатахууны зарцуулагдаагүй үлдэгдэл тайлагнасан.

Үндсэн хөрөнгө: АХБ-ны санхүүжилтээр төслийн нэгжийн үйл ажиллагаанд зориулан худалдан авсан нийт 279,444.3 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, компьютер,

тавилга эд хогшлыг үндсэн хөрөнгөөр, нийт 8,250.0 мянган төгрөгийн санхүүгийн болон төсвийн программ хангамжийг биет бус хөрөнгөөр тус тус бүртгэсэн. Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгөнд нийт 30,125.9 мянган төгрөгийн элэгдэл байгуулж зардлаар бүртгэсэн.

Дуусаагүй барилга: Барилгын ажлын гэрээний гүйцэтгэгчдэд төлсөн явцын төлбөрийн 1,550,817.0 мянган төгрөг, зураг төсөл боловсруулах ажлын төлбөрийн 100,010.5 мянган төгрөгийн үлдэгдлийг хуримтлуулан тайлагнасан.

Богино хугацаат өр төлбөр: Барилгын ажлын гүйцэтгэгчийн нэхэмжилсэн 178,217.7 мянган төгрөгийн явцын төлбөр болон төсөл хэрэгжүүлэгч нэгжийн оффисын байрны түрээсийн төлбөрийн нийт 10,218.6 мянган төгрөгийг богино хугацаат өр төлбөрөөр тайлагнасан.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

“Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг санхүүжүүлэхэд зориулан 2019 онд 12,800,000.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 10,000,000.0 мянган төгрөгийг урсгалд зардалд, 2,800,000.0 мянган төгрөгийн хөрөнгийн зардалд тус тус зарцуулахаар батлагджээ.

Төсвийн орлогын гүйцэтгэл 12,603,881.7 мянган төгрөг буюу 98.5 хувьтай байна. Төсвийн урсгал зардлын гүйцэтгэл 9,921,183.0 мянган төгрөг буюу 99.2 хувь, хөрөнгийн зардлын гүйцэтгэл 2,556,130.6 мянган төгрөг буюу 91.3 хувьтай байна.

Хүснэгт 2. Төсвийн орлого

/ мянган төгрөг/

Санхүүжилтийн төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	12,800,000.0	12,603,881.7	196,118.3	98.5
Нийт дүн	12,800,000.0	12,603,881.7	196,118.3	98.5

Хүснэгт 3. Төсвийн зардал

/ мянган төгрөг/

Зарцуулалтын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Урсгал зардал	10,000,000.0	9,921,183.0	78,817.0	99.2
Хөрөнгийн зардал	2,800,000.0	2,556,130.6	243,869.4	91.3
Нийт дүн	12,800,000.0	12,477,313.6	560,297.6	97.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 2 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 3 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар мөнгөний гүйлгээний тайланг буруу бэлтгэсэнтэй холбоотой 7,880,796.4 мянган төгрөгийн алдаа илрүүлсэнээс 7,880,796.4 мянган төгрөгийн 1 алдааг залруулж,

алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Аудитын явцад санхүүгийн тайланд дараах залруулгыг хийв. Үүнд:

Мөнгөн гүйлгээний тайланд АХБ-ны шууд төлбөрийн нийт дүн 7,880,796.4 мянган төгрөгийг тусгаснаас шалтгаалан төсвийн гүйцэтгэлийн тайлан болон төсвийн тохируулгын тайлан буруу бэлтгэгдсэн.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар дор дурдсан асуудлуудыг анхаарч үзэх шаардлагатай. Үүнд:

- Төсвийн тухай хуульд олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх төслийн нэгж нь төсвийн байгууллага байхаар зааснаар нягтлан бодох бүртгэлээ УСНББОУС-ын дагуу бүрэн аккруэл сууриар бүртгэхтэй холбоотойгоор олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаанд тохирсон нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын нэгдсэн заавар, аргачлалыг Сангийн яамнаас тусгайлан гаргах хэрэгтэй байна. Уг заавар, аргачлалд төслийн нэгж нь АХБ-ны зарцуулалтын үндсэн процедур болох шууд төлбөр, урьдчилгаа төлбөр, нөхөн дүүргэлтийг аккруэль сууриар хэрхэн хүлээн зөвшөөрч бүртгэж тайлагнах, хүлээн авсан болон зарцуулсан санхүүжилтэнд гадаад валютын ханшийг хэрхэн ашиглах, төслийн санхүүжилтээр бий болсон биет болон биет бус хөрөнгийг элэгдүүлэх хугацаа болон арга, төслийн санхүүжилтээр хийгдэж байгаа барилга, байгууламж, худалдан авч бусад байгууллагад шилжүүлсэн тоног төхөөрөмжийг хэрхэн хуримтлуулан бүртгэх, төслийн хэрэгжүүлэгч нэгжийн хөрөнгийг төсөл дуусахад төрийн өмчид хэрхэн шилжүүлэх, зээл тусламжийг төслийн нягтлан бодох бүртгэлд өр төлбөрөөр тусгах эсэх, зээлийн хүүгийн өр төлбөрийг хэрхэн бүртгэх;
- Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд шаардсан мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн оруулсан эсэхийг хянах;
- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөө болон төсвийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг эдийн засгийн ангиллаар нь задалж тайлагнаж байгаа эсэхийг хянах;
- АХБ-наас 2018 оны 12 дугаар сард хийсэн үнэлгээгээр БСШУСЯ-нд Тендерийн Үнэлгээний Хорооны бүрэлдэхүүнд төслийн худалдан авалтын ажилтанг оруулж байх саналыг тавьсан.

2.12. Шилэн дансны мэдээлэл

“Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл” нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 13 мэдээллийг хугацаанд нь, 118 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд санхүүгийн тайлан бэлтгээгүй.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

“Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн 2019 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Санхүүгийн программ хангамжийн талаар

3.1.1 Илрүүлэлт:

Төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Инфосистемс” ХХК-ийн “Пакс” санхүүгийн программ хангамж ашигладаг.

Тус программ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцээгүй, харин АХБ-ны Зарцуулалтын журмын шаардлагын дагуу мөнгөн сууриар нягтлан бодох бүртгэл хөтлөхөөр тохируулга хийгдсэн байна.

Энэ нь иж бүрэн байх, үнэн зөв байх, тодруулга ба толилуулга, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцээгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14-р зүйлийн заалттай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Төслийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал буруу, алдаатай бэлтгэгдэх;

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төслийн санхүүгийн программыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-ын шаардлагад нийцүүлсэн байдлаар шинэчлэх, холбогдох өөрчлөлт оруулах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

ТХН-ийн зүгээс уг санхүүгийн программыг иж бүрэн болгох тал дээр программ зохиогч компанитай илүү хамтран ажиллаж байгаа. Одоогийн байдлаар Монгол Улсын хэмжээнд ам.долларын тайланг гаргадаг ганц л программ байдаг бөгөөд тэр нь Инфосистемийн "Пакс" юм. Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 Шилэн дансны мэдээллийн талаар

3.2.1 Илрүүлэлт:

Төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 13 мэдээллийг хугацаанд нь, 118 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

3.2.2 Эрсдэл:

Шилэн дансны тухай хууль зөрчих;

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу мэдээллийг тогтсон хугацаанд нь бүрэн гүйцэт оруулах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Шилэн дансанд системд ижил төрлийн мэдээллийг сар, улирал, жил бүр давтан оруулах шаардлагатай болдог, заримдаа системийн ачааллаас хамааран мэдээллээ хадгалаагүй хаасан зэргээс хамаарч мэдээллийг хугацаа хоцорч оруулсан.

3.3. НДШ, ХХОАТ-ын тооцоолол, төлөлт

3.3.1. Илрүүлэлт:

Төслийн анхны санхүүжилт 2019 оны 01 дүгээр сард орж ирсэнтэй холбоотойгоор төслийн ажилтнуудын 2018 оны 10-12 дугаар сарын цалин, 2019 оны 1 дүгээр сарын цалинг нэгтгэн тооцож, ажил олгогчийн болон даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг суутган тооцож, тайлагнасан.

3.3.2 Эрсдэл:

Нийгмийн даатгалын тухай хууль, хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн заалт зөрчигдөх;

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Төслийн ажилтантай хөлсөөр ажиллах гэрээ байгуулагдмагц тэр хугацаанаас эхлэн цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын тооцооллыг төслийн санхүүжилт орж ирсэн эсэхээс үл шалтгаалан тооцож, холбогдох байгууллагууд руу тайлагнах.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Энэ нь ТХН нь 2018 оны 10 дугаар сард байгуулагдсан цагаасаа эхлэн санхүүжүүлэгч байгууллагын тухайн үед баримталж байсан Нягтлан бодох бүртгэлийн мөнгөн сууриар бүртгэлээ хөтөлж байсантай холбоотой. АХБ-наас 2019 оны 3 дугаар сарын 15-ны 102/19 тоот албан тоотоор НББ-ын мөнгөн сууриас аккрузал суурьт шилжих болсноо мэдэгдсэн байгаа. Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ Төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	160,953,325.42
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	138,835,449.90
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	138,835,449.90
31210	Төгрөг	0.00	27,396,372.61
31211	Төрийн сангийн харилцах	0.00	27,396,372.61
31220	Гадаад валют	0.00	111,439,077.29
31223	Арилжааны банк дахь харилцах	0.00	111,439,077.29
33	АВЛАГА	0.00	13,882,618.52
33500	Бусад авлага	0.00	13,882,618.52
33510	Байгууллагаас авах авлага	0.00	13,882,618.52
35	БАРАА МАТЕРИАЛ	0.00	8,235,257.00
35400	Хангамжийн материал	0.00	8,235,257.00
35410	Бичиг хэргийн материал	0.00	374,000.00
35420	Аж ахуйн материал	0.00	6,398,600.00
35430	Сэлбэг хэрэгсэл	0.00	1,072,400.00
35440	Түлш, шатах тослох материал	0.00	390,257.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	1,908,395,779.52
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	0.00	1,908,395,779.52
39200	Биет хөрөнгө	0.00	1,901,636,397.80
39203	Авто-тээврийн хэрэгсэл	0.00	189,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(15,445,161.29)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	0.00	69,646,600.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(11,283,873.33)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	0.00	20,797,700.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(1,906,455.83)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	0.00	1,650,827,588.25
39300	Биет бус хөрөнгө	0.00	6,759,381.72
39301	Програм хангамж	0.00	8,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(1,490,618.28)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	0.00	2,069,349,104.94
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	188,436,297.60
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	188,436,297.60
41300	Өглөг	0.00	188,436,297.60
41360	Бусад өглөг	0.00	188,436,297.60
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	178,217,697.60
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	10,218,600.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	0.00	1,880,912,807.34
51	Засгийн газрын хувь оролцоо	0.00	1,880,912,807.34
51200	Хуримтлагдсан үр дүн	0.00	1,880,912,807.34
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	1,880,912,807.34
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	0.00	2,069,349,104.94

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

			/ Төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	0.00	12,622,460,593.08
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	12,622,460,593.08
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	12,622,460,593.08
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	12,622,437,241.08
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	18,555,485.58
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	0.00	12,603,881,755.50
120009	Бусад орлого	0.00	23,352.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	0.00	10,753,791,757.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	10,753,791,757.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	10,734,336,271.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	634,072,438.26
210101	Үндсэн цалин	0.00	634,072,438.26
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	78,032,487.84
210201	Тэтгэврийн даатгал	0.00	53,896,157.26
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	6,340,724.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	4,626,555.16
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	1,602,663.14
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	11,566,387.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	81,262,532.00
210301	Гэрэл, цахилгаан	0.00	1,305,228.10
210302	Түлш, халаалт	0.00	1,495,395.60
210303	Цэвэр, бохир ус	0.00	335,518.60
210304	Байрны түрээс	0.00	78,126,389.70
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	24,146,304.97
210401	Бичиг хэрэг	0.00	6,798,289.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	11,683,049.30
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	5,664,966.67
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	772,650.00
210604	Урсгал засвар	0.00	772,650.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	8,245,372.70
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	0.00	4,606,393.70
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	3,638,979.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	195,661,113.49
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	135,836,126.57
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	2,018,304.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	142,123.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	57,350,150.00

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	314,409.92
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	9,712,143,372.73
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	9,231,476,814.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	450,540,450.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	0.00	30,126,108.73
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	19,455,485.58
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	900,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	900,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	18,555,485.58
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	18,555,485.58
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	0.00	1,868,668,835.51
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	21,189,321.06
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	0.00	21,189,321.06
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	8,945,349.23
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	0.00	8,945,349.23
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	0.00	1,880,912,807.34

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

			/ Төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	0.00	4,749,890,838.07
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	4,749,890,838.07
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	4,749,890,838.07
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	4,741,640,838.07
1200042	Туслах үйл ажиллагааны санхүүжилт	0.00	18,555,485.58
120009	Бусад орлого		8,250,000.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	0.00	4,723,085,352.49
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	3,756,301,670.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	3,756,301,670.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	3,737,746,184.77
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	3,729,519,536.77
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	3,729,519,536.77
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	8,226,648.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	8,226,648.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	18,555,485.58
213306	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	18,555,485.58
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.00	993,589,167.72
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	866,997,689.65
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	866,997,689.65
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	866,997,689.65
220001	Барилга байгууламж	0.00	11,630,295.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	855,367,394.65
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	(866,997,689.65)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.00	12,243,971.83
14	Бусад эх үүсвэр	0.00	12,243,971.83
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	0.00	12,243,971.83
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	138,835,449.90
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	138,835,449.90
100	Тохируулгын орлого, зарлагын зөрүү	0.00	0.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан Дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	0.00	0.00
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,880,912,807.34	1,880,912,807.34
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,880,912,807.34	1,880,912,807.34

/ Төгрөгөөр /

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ Төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,800,000,000.00	12,477,313,629.42	322,686,370.58	97.48%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,000,000,000.00	9,921,183,017.77	78,816,982.23	99.21%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,000,000,000.00	9,921,183,017.77	78,816,982.23	99.21%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	0.00	10,000,000.00	0.00%
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00	0.00	10,000,000.00	0.00%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,990,000,000.00	9,921,183,017.77	68,816,982.23	99.31%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,990,000,000.00	9,921,183,017.77	68,816,982.23	99.31%
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,800,000,000.00	2,556,130,611.65	243,869,388.35	91.29%
220001	Барилга байгууламж	1,500,000,000.00	1,380,880,611.65	119,119,388.35	92.06%
222001	Тоног төхөөрөмж	1,300,000,000.00	1,175,250,000.00	124,750,000.00	90.40%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,800,000,000.00	12,603,905,107.49	196,094,892.51	98.47%
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	12,800,000,000.00	12,603,905,107.49	196,094,892.51	98.47%
350004	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	12,800,000,000.00	12,603,881,755.49	196,118,244.51	98.47%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	126,591,478.07		
6	АЖИЛЛАГСАДЫН ТОО				
	Гэрээт ажилтан		10		

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020.04.27	Аудитын нэр: “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код: САГ-2020/733/СТА-ТХН
Шалгагдсан байгууллагын нэр:	“Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”	Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Инфосистемс” ХХК-ийн “Пакс” санхүүгийн программ хангамж ашигладаг. Тус программ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцээгүй, харин АХБ-ны Зарцуулалтын журмын шаардлагын дагуу мөнгөн сууриар нягтлан бодох бүртгэл хөтлөхөөр тохируулга хийгдсэн байна. Энэ нь иж бүрэн байх, үнэн зөв байх, тодруулга ба толилуулга, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцээгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14-р зүйлийн заалттай нийцэхгүй байна.	-	Зөвлөмж өгөх	Төслийн зохицуулагч	3. Мөнхтуяа
2	Төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 13 мэдээллийг хугацаанд нь, 118 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.	-	Зөвлөмж өгөх	Төслийн зохицуулагч	3. Мөнхтуяа
3	Төслийн анхны санхүүжилт 2019 оны 01 дүгээр сард орж ирсэнтэй холбоотойгоор төслийн ажилтнуудын 2018 оны 10-12 дугаар сарын цалин, 2019 оны 1 дүгээр сарын цалинг нэгтгэн тооцож, ажил олгогчийн болон даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг суутган тооцож, тайлагнасан.	-	Зөвлөмж өгөх	Төслийн зохицуулагч	3. Мөнхтуяа
	Зөвлөмжийн дүн	-			